

ШУТИС-ИЙН ГАДААД ХЭЛНИЙ НЭГДСЭН ШАЛГАЛТ

(АНГЛИ ХЭЛ)

Шалгалт авах хугацаа: 2025 оны 4 сарын 10 (09:22 цагийн хооронд)

Шалгалтын хэлбэр: цахим (TEST-Center)

Гадаад хэлний нэгдсэн шалгалтыг цахимаар зохион байгуулах бөгөөд тестийн үргэлжлэх хугацаа 60 минут байна. Магистрийн хөтөлбөрт тусгагдсан гадаад хэлний нэгдсэн шалгалтын хүрээнд (Англи хэл) дараах агуулгыг судалсан байх шаардлагатай.

Хэл зүйн дүрэм: /25 оноо/ Хэл зүйн дүрмийн хувьд дараах мэдлэгээг, чадварыг эзэмшин, хэрэглээ болгосон байх. Үүнд: үйл үг үйлийн эзний зохицол, (Subject-Verb Agreement), үгсийн аймаг, (Recognizing Word Forms, Articles, Prepositions, Pronouns, Adverbs and Adjectives), Үйлт нэр, (Gerunds), үйл үгийн тодорхойгүй хэлбэр, (Infinitives), үйл үгийн идэвхтэй болон идэвхгүй хэлбэр, (Active and Passive Voice), гишүүн өгүүлбэрийн төрөл (Clauses of English). Хэл зүйн дүрмийг олон улсын стандарт шалгалтын загвар болох сонгох хариулт бүхий хувилбартай байна. Шалгалтын бэлтгэлийн явцад оюутнууд загвар тест дээр ажиллах, ерөнхий тактикт суралцах, бөгөөд ажлын байрны англи хэлний TOEIC шалгалтын бүтцийг судлан ажиллах хэрэгтэй.

ҮГИЙН САН/25 оноо/ Энэ хэсэгт англи хэлний ерөнхий үгийн баялаг шалгах тест байх ба орхигдсон хэсэгт тодорхой үгийг сонгож өгүүлбэрийн утгыг алдагдуулахгүй байх даалгавар байна. Үгийн сан бол хэлний бүх ур чадварын үндсэн суурь ур чадвар юм. Тусгай загвар тест дээр ажиллан үгийн олон утга, ойролцоо утга, эсрэг утга зэргийг судлан англи хэлний чадвараа сайжруулах хэрэгтэй.

УНШИХ/10 оноо/ Энэхүү унших хэсэг нь оюутны ерөнхий болон суурь шинжлэх ухааны болон бизнесийн текстийг ойлгох, асуултад хариулах, утга ижил үгээр илэрхийлсэн үгийг ойлгох чадвар, мөн тухайн мэдээллийг уншлагын тактикт (Skimming and scanning) хэрэглэн богино хугацаанд зөв мэдээллийг олох, анализ дүгнэлт хийх ур чадварыг шалгах хэсэг юм. Мөн тестийн асуултууд олон улсын стандарт шалгалтын загвараар боловсруулагдсан байна. Энэ төрлийн даалгаварт бэлдэхийн тулд оюутнууд өгүүлбэрийн бүтэц, холбоо үг, гишүүн өгүүлбэрийн төрөл, академик англи хэлний ур чадвар, хэрэглээ, утга шилжилт, тоон мэдээллийг унших аргачлал, ерөнхий мэдээллийг дүгнэн унших ур чадвар, унших ур чадварын тактикт эзэмшсэн байх шаардлагатай. Төрөл бүрийн эх сэдэв дээр ажиллан унших, ойлгох ур чадвараа хөгжүүлэх нь чухал.

ГХС. АНГЛИ ХЭЛНИЙ ТЭНХИМ